




ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ СТАТИСТИК 2021

Улаанбаатар хот
2022 он



Статистик үзүүлэлтийг боловсруулж, эмхэтгэсэн:

Э.Шинэцэцэг
/Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтсийн статистикч их эмч, цагдаагийн ахлах дэслэгч/

Хянасан:

Б.Эрдэнэхүү
/Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн хошууч/

Статистик мэдээ бэлтгэсэн:

Д.Орхонсэлэнгэ
/Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн, цагдаагийн хошууч/

Р.Баярмаа
/Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад/

А.Болормаа
/Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад/

Б.Бат-Уянга
/Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын олон нийттэй харилцах, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч/

Хэвлэлийн эхийг: Б.Чулуунбат
Хэвлэлийн хуудас: 3.2
Цаасны хэмжээ: В5 (176x250)
Хэвлэсэн тоо: 100
Хэвлэсэн хугацаа: 2022 оны 3 дугаар сар

“ЧУБАМАРА” ХХК-д бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	4
ШИНЖИЛГЭЭ	5
Криминалистикийн шинжилгээ	8
Тусгай шинжилгээ	17
Шүүх эмнэлгийн шинжилгээ	23
Эдийн засгийн шинжилгээ	43
ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ	44
Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгт оролцсон байдал	45
Шинжээч эмч нар хэргийн газрын үзлэгт оролцсон байдал	49

ӨМНӨТГӨЛ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтсээс тус байгууллагын 2021 онд улсын хэмжээнд хийгдсэн шинжилгээг бүртгэл, мэдээллийн чиг үүргийн дагуу урьд жилүүдэд хийгдсэн шинжилгээний тоотой харьцуулж, тоон үзүүлэлтүүдээр диаграмм, хүснэгтэн мэдээлэл боловсруулж 9 дэх жилдээ та бүхэнд хүргэж байна.

Бэлтгэнхүргүүлжбуй“Шүүхийншинжилгээнийстатистик2021”товхимолд урьд жилүүдэд хийсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан харуулсан нь шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, судалгаа, шинжилгээ хийх, мөн цаашилбал төсөв, төлөвлөгөө боловсруулах зэрэгт чухал ач холбогдолтой гэдгийг дурдах нь зүйтэй.

Энэхүү “Шүүхийн шинжилгээний статистик 2021” товхимлыг та бүхэн судалгаа, шинжилгээний үйл ажиллагаандаа үр бүтээлтэй ашиглана гэдэгт итгэж байна.


Эмхэтгэлтэй танилцаж, судалсан та бүхэн цаашид шинжилгээний статистикийг боловсронгуй болгох, сайжруулах тал дээр санал, зөвлөмж, шүүмжээ Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтсийн burtgel.medeel@nifs.gov.mn хаягаар ирүүлэхийг хүсье.

ДҮН ШИНЖИЛГЭЭ, БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд 58424 шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 9.2 хувиар буурсан бөгөөд нийт шинжилгээний 57.5 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 27 хувийг тусгай шинжилгээ, 15 хувийг криминалистикийн шинжилгээ, 0.3 хувийг эдийн засгийн шинжилгээ эзэлж байна.

Диаграмм 1. 2021 онд хийгдсэн нийт шинжилгээг чиглэл тус бүрээр харуулав.



Хүснэгт 1. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг сүүлийн 6 жилээр харьцуулав.

Шинжилгээний чиглэл, төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	
Криминалистикийн шинжилгээ	Гарын мөр	10319	9541	9550	7499	6660	5384
	Мөр судлал	2012	1545	1553	1740	1556	1394
	Бичиг баримт	1207	1066	906	1147	915	684
	Дүр зураг	133	98	72	53	37	15
	Галт зэвсэг	249	222	604	937	877	677
	Тэсрэх төхөөрөмж	7	7	2	6	13	2
	Дүрс бичлэг	229	265	251	237	244	243
	Авто техник	218	235	165	164	215	226
	Компьютер судлал	132	131	111	85	119	77

Тусгай шинжилгээ	Дуу авиа	-	-	28	24	23	15
	Материал судлал	-	-	32	52	5	40
	Бусад	116	92	19	17	29	9
	Бүгд	14622	13202	13293	11961	10693	8766
	Хими	5348	5894	6814	7524	6976	6931
	Физик	179	170	210	238	249	133
	Биологи	5734	5679	6056	6560	6125	5977
	ДНХ	1070	1265	1685	2046	2030	1757
	Бактериологи	893	994	1049	989	1062	1038
	Бүгд	13224	14002	15814	17357	16442	15836
Шүүх эмнэлгийн шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	3685	4016	4492	4659	4456	4561
	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	30168	27934	27493	27138	25919	22949
	Хүний биед хийсэн бусад шинжилгээ	1209	1220	1425	1575	1734	1686
	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1716	1409	1430	1649	1504	1178
	Шарилд хийсэн шинжилгээ /эксгумац/	24	19	26	24	17	11
	Гистологийн шинжилгээ	3621	3492	4913	5110	3345	3246
	Бүгд	40423	38090	39779	40155	36974	33631
Эдийн засгийн шинжилгээ	Татвартай холбоотой	11	18	20	9	11	7
	НД-ын шимтгэлтэй холбоотой	21	24	21	3	14	8
	Бэлэн мөнгөтэй холбоотой	70	48	53	64	75	51
	Эд хогшил, бараа	57	46	36	46	46	35
	Бусад зөрчил	5	95	13	30	20	16
	Буцсан	0	0	90	85	94	74
	Бүгд	256	231	233	237	260	191
	НИЙТ	68525	65525	69119	69710	64369	58424

График 1. Шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 6 жилийн байдлаар)





График 2. Шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 6 жилийн байдлаар)



КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд криминалистикийн 8766 шинжилгээ хийсэн бөгөөд 40.6 хувийг Криминалистикийн шинжилгээний газарт, 36 хувийг Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн лабораторид, 23.4 хувийг аймгуудын шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн лабораторид хийсэн байна.

Хүснэгт 2. Криминалистикийн шинжилгээний 2021 оны статистик мэдээ

Аймаг	Нийт шинжилгээ	Үүнээс шинжилгээний төрөл:																				
		Гарын мөр	Мөр судлал	Бичиг баримт	Галт зэвсэг	Тэсрэх төхөөрөмж	Дүр зураг	Дүрс бичлэг	Авто техник	Компьютер судла	Дуу авиа	Материал судлал	Бусад									
Архангай	65	46	9	9	1																	
Баян-Өлгий	43	12	11	20																		
Баянхонгор	76	43	24	9																		
Булган	60	38	14	8																		
Говь-Алтай	40	23	10	5	2																	
Говьсүмбэр	12	4	6	2																		
Дархан-Уул	105	63	27	15																		
Дорноговь	107	83	17	7																		
Дорнод	151	126	24	1																		
Дундговь	80	65	11	4																		
Завхан	54	23	17	11	3																	
Орхон	167	116	39	11	1																	
Өвөрхангай	130	83	40	5																		2
Өмнөговь	36	25	10	1																		
Сүхбаатар	33	23	7	1	2																	
Сэлэнгэ	143	112	23	8																		
Төв	194	167	26	1																		
Увс	63	32	13	13	5																	
Ховд	94	49	32	12	1																	
Хөвсгөл	225	153	39	8	24				1													
Хэнтий	172	128	41	1	2																	
НШШГ	3154	3137	10	7																		
КШГ	3562	833	944	525	636	2	15	243	225	77	15	40	7									
Бүгд	8766	5384	1394	684	677	2	15	243	226	77	15	40	9									

Диаграмм 2. Криминалистикийн шинжилгээг хийсэн газар, албаар нь харьцуулан харуулав.






График 3. Сүүлийн 3 жилд хийгдсэн Криминалистикийн зарим шинжилгээг харьцуулан харуулав.



КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Криминалистикийн шинжилгээний газарт 2020 онд 138701 объекттой, 4683 шинжилгээ хийсэн бол 2021 онд 69140 объекттой, 3562 шинжилгээ хийсэн нь өмнөх онохоос 23 хувиар буурсан байна.

График 4. Криминалистикийн шинжилгээний газарт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт



Нийт хийгдсэн шинжилгээний 93.8 хувийг мөрдөгчийн тогтоолоор, 4.6 хувийг шүүгчийн захирамж, тогтоолоор, 1.1 хувийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр, 0.3 хувийг прокурорын тогтоолоор хийсэн байна.

Диаграмм 3. Криминалистикийн шинжилгээг хийсэн үндэслэл



Цагдаагийн байгууллагаас шинжилгээ хийлгэсэн нь тус газарт хийсэн нийт шинжилгээний 93.8 хувийг эзэлж байгаа бөгөөд бусад шинжилгээг шүүх, прокурор, бусад эрх бүхий байгууллагын тогтоол, захирамж, хүсэлтээр хийсэн байна.

График 5. Шүүхээс ирүүлсэн криминалистикийн шинжилгээний тоон үзүүлэлт




График 6. Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн криминалистикийн шинжилгээний тоон үзүүлэлт






График 7. Шинжилгээ ирүүлсэн бусад байгууллагууд



НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжилгээний лабораториудад 2020 онд 3911 шинжилгээ хийсэн бөгөөд 2021 онд 3154 шинжилгээ хийсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 19.3 хувиар буурсан байна.

График 8. Нийслэлийн шүүхийн шинжилгээний албанд хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт



Шинжилгээг төрлөөр нь авч үзвэл гарын мөрний шинжилгээ дийлэнх хувийг буюу 99.4 эзэлж байгаа бөгөөд нийт шинжилгээг мөрдөгч, прокурорын тогтоолоор хийжээ.

АЙМГУУДЫН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД ХИЙСЭН КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ

Аймгуудын Шүүхийн шинжилгээний албанд криминалистикийн нийт 2050 шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 2.3 хувиар буурсан байна. Хамгийн олон шинжилгээ буюу 225 шинжилгээг Хөвсгөл аймаг, 194 шинжилгээг Төв, 172 шинжилгээг Хэнтий аймгийн шүүхийн шинжилгээний албанд хийсэн байна.

Нийт шинжилгээний 69 хувийг гарын мөр, 21.5 хувийг мөр судлал, 7.4 хувийг баримт бичгийн шинжилгээ, 2 хувийг галт зэвсгийн шинжилгээ эзэлж байна.

Диаграмм 4. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийгдсэн криминалистикийн нийт шинжилгээг төрлөөр нь харуулав.






График 9. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн криминалистикийн шинжилгээний тоон үзүүлэлт



Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн криминалистикийн шинжилгээний нийт дүнд гарын мөрний шинжилгээ дийлэнх хувийг эзэлж байгаа бол Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад мөр судлалын шинжилгээ харьцангуй их хувийг эзэлж байна.

График 10. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн криминалистикийн шинжилгээг төрлөөр нь харьцуулан харуулав



ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд тусгай шинжилгээний чиглэлээр нийт 15836 шинжилгээ хийснийг өмнөх онтой харьцуулахад 3.7 хувиар буурсан байна.


2021 онд Тусгай шинжилгээний чиглэлээр хийгдсэн нийт шинжилгээний 43.7 хувийг хими, 37.7 хувийг биологи, 11 хувийг ДНХ, 6.5 хувийг бактериологи, 0.8 хувийг физикийн шинжилгээ тус тус эзэлж байна.

Дээрх шинжилгээний 85 хувь нь Тусгай шинжилгээний газарт, 15% хувийг аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн.

Хүснэгт 3. Тусгай шинжилгээний 2021 оны статистик мэдээнээс.

Аймаг	Нийт шинжилгээ	Үүнээс шинжилгээний төрөл:				
		Хими	Физик	Биологи	ДНХ	Бактериологи
Архангай	298	171		127		
Баян-Өлгий	126	126				
Булган	83	83				
Говь-Алтай	143	97		46		
Дархан-Уул	235	133		102		
Дорнод	259	206		53		
Завхан	142	142				
Орхон	350	256		94		
Сүхбаатар	93	93				
Сэлэнгэ	84	60		24		
Увс	207	117		90		
Ховд	175	143		32		
Хөвсгөл	189	189				
ТШГ	13452	5115	133	5409	1757	1038
Бүгд	15836	6931	133	5977	1757	1038

Диаграмм 5. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдсэн хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ /тоогоор/



ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Тусгай шинжилгээний газарт 2021 онд 13452 шинжилгээ хийгдсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 4 хувиар буурсан байна.

Нийт шинжилгээг төрлөөр нь авч үзвэл биологийн 5409, химийн 5115 шинжилгээ зонхилох хувийг эзэлж байна.

График 11. Тусгай шинжилгээний газарт сүүлийн 3 жилд хийгдсэн шинжилгээ






График 12. 2021 онд Тусгай шинжилгээний газарт хийгдсэн шинжилгээг шинжилгээ хийсэн үндэслэлээр



Диаграмм 6. 2021 онд Тусгай шинжилгээний газарт хийсэн хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээний тоон үзүүлэлт



Тусгай шинжилгээний газарт хийсэн шинжилгээнүүдийг томилсон байгууллагаар нь авч үзвэл цагдаа, шүүх, прокурорын байгууллагын тогтоолоор 5221, шүүгчийн захирамжаар 432, төрийн эрх бүхий байгууллагын албан бичгээр 20, шинжээч эмчийн илгээх бичгээр 7779 шинжилгээ хийлгэсэн байна.

Диаграмм 7. Тусгай шинжилгээний газарт шинжилгээ томилж ирүүлсэн байгууллага




График 13. Тусгай шинжилгээний газарт нийслэл дэх цагдаагийн байгууллагаас ирүүлсэн шинжилгээний тоон үзүүлэлт




График 14. Тусгай шинжилгээний газарт нийслэл дэх шүүхээс ирүүлсэн шинжилгээний тоон үзүүлэлт





График 15. Тусгай шинжилгээний газарт хийсэн орон нутгийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шинжилгээний тоон үзүүлэлт



АЙМГУУДЫН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД ХИЙСЭН ХИМИ, БИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ

Хими, биологийн лаборатори бүхий аймгуудын шүүхийн шинжилгээний албанд нийт 2384 шинжилгээ хийсэн бөгөөд өмнөх жилээс 2 хувиар буурсан байна. Орхон, Архангай, Дорнод аймгийн шүүхийн шинжилгээний албанд хамгийн их шинжилгээг хийсэн байна.

График 16. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд сүүлийн 3 жилд тусгай шинжилгээний чиглэлээр хийсэн шинжилгээ





График 17. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн хими, биологийн шинжилгээний тоон үзүүлэлт




ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд шүүх эмнэлгийн чиглэлээр 33631 шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь өмнөх оныхоос 9 хувиар буурсан байна. Эдгээрийн 73 хувь нь хүний биед хийсэн шинжилгээ, 13.6 хувь нь цогцост хийсэн шинжилгээ, 9.6 хувь эд эсийн шинжилгээ, 3.5 хувь нь хэргийн материалаар хийсэн шинжилгээ эзэлж байгаа бөгөөд нийт шинжилгээний 53.3 хувийг Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 3.3 хувийг Нийслэлийн Шүүхийн шинжилгээний албанд, 43.4 хувийг аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн.

Хүснэгт 4. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээг төрлөөр нь харуулав.

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	4561
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	22949
Хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох)	1686
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1178
Эксгумац	11
Гистологийн шинжилгээ	3246
НИЙТ	33631


Диаграмм 8. Шүүх эмнэлгийн шинжилгээ хийгдсэн төрлөөр.



Хүснэгт 5. Шүүх эмнэлгийн шинжилгээний статистик мэдээнээс.

№	Шинжилгээний алба	Нийт шинжилгээ	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Хүний биед хийсэн бусад шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	эксгумац	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	Гистологи
1	Архангай	557	415	16	112		14	
2	Баян-Өлгий	643	576	11	55	1		
3	Баянхонгор	682	470	61	94		57	
4	Булган	361	236	42	81		2	
5	Говь-Алтай	494	399	23	70		2	
6	Говьсүмбэр	391	363	2	26			
7	Дархан-Уул	939	780	54	85			20
8	Дорноговь	709	597	24	88			
9	Дорнод	935	585	35	150		5	160
10	Дундговь	367	273	13	56		25	
11	Завхан	527	421	17	66			23
12	Орхон	849	678	53	109		9	
13	Өвөрхангай	608	438	55	113	2		
14	Өмнөговь	798	616	32	132		15	3
15	Сүхбаатар	590	525	26	39			
16	Сэлэнгэ	813	626	19	168			
17	Төв	1041	574	17	170		109	171
18	Увс	677	486	24	77	1	3	86
19	Ховд	917	738	20	70		20	69
20	Хөвсгөл	765	515	48	202			
21	Хэнтий	921	711	38	149		23	
22	ШЭШГ	17940	10972	1033	2331	7	883	2714
23	НШШГ	1107	955	23	118		11	
24	Бүгд	33631	22949	1686	4561	11	1178	3246

График 18. Сүүлийн 3 жилд хийгдсэн Шүүх эмнэлгийн нийт шинжилгээ.



Диаграмм 9. Шүүх эмнэлгийн шинжилгээ хийгдсэн байдал.





График 19. Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээгээр тогтоогдсон нас баралтын зонхилох шалтгаанууд /улсын хэмжээнд/



Хүснэгт 6. Нас баралтын шалтгаанууд /улсын хэмжээнд/

№	Нас баралтын шалтгаан	Бүгд	Эр	Эм
1	Мохоо	224	196	28
2	Зам тээврийн осол	475	376	99
3	Төмөр замын осол	5	3	2
4	Хутгалагдсан шарх	103	89	14
5	Буудагдсан шарх	30	28	2
6	Дүүжлэлт	528	448	80
7	Өндрөөс уналт	150	104	46
8	Амьсгаа боох бусад осол	112	95	17
9	Осголт	200	154	46
10	Түлэгдэлт	34	27	7
11	Живэлт	152	118	34
12	Угаарын хийн хордлого	184	142	42
13	Архины хордлого	908	734	174
14	Хоолонд хордох	1	1	0
15	Эмэнд хордох	4	2	2
16	Бусад зүйлээр хордох	20	12	8
17	Өвчин	1197	955	242
18	Эхийн эндэгдэл	5	1	4
19	Нярай	26	17	9
20	Хорт хавдар	14	8	6
21	Халдварт өвчин	3	1	2
22	Шалтгаан тодорхойгүй	85	72	13
23	Цахилгаан гүйдлийн гэмтэл	14	13	1
24	Бусад осол	83	64	19
Нийт		4557	3660	897


ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 2021 онд 17940 шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 5.7 хувиар буурсан байна. Шинжилгээний төрөл, чиглэлээр нь авч үзвэл хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 61 хувь, хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох) 5.7 хувь, цогцост хийсэн шинжилгээ 13 хувь, эд эсийн шинжилгээ 15 хувь, хэргийн материалаар хийсэн шинжилгээ 4 хувь, шарилд хийсэн шинжилгээ 0.03 хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн шинжилгээг төрлөөр нь харуулав

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	2331
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	10972
Хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох)	1033
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	883
Шарилд хийсэн шинжилгээ (эксгумаци)	7
Гистологийн шинжилгээ	2714
НИЙТ	17940

Диаграмм 10. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийсэн нийт шинжилгээнд төрөл, чиглэлийн эзлэх хувь



Цогцост хийсэн шинжилгээ:

Тус газар 2021 онд шинжилгээ хийлгэх тогтоолын дагуу **2658** цогцсыг хүлээн авч бүртгэснээс **2331** цогцост шинжилгээ хийж, **327** цогцост эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр шинжилгээ хийгдээгүй байна.

График 20. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 2021 онд хийгдсэн цогцост хийсэн шинжилгээгээр тогтоогдсон нас баралтын шалтгааныг харуулав.




График 21. Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээгээр тогтоогдсон зонхилох хоёр шалтгааныг насны ангиллаар харуулав



Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын эд эсийн лабораторид Шүүх эмнэлгийн шинжилгээний газар болон хөдөө орон нутгийн шинжилгээний албанд хийгдсэн цогцос шинжилгээний болон хэргийн материалаар ирүүлсэн шинжилгээний эд эсийг шинжилдэг бөгөөд тус онд 2151 секцийн 28360 блокт шинжилгээ хийсэн байна .





График 22. ШЭШГ-т цогцост хийсэн шинжилгээг шинжээч томилсон байгууллагаар нь ангилан харуулав.



Тус онд 2331 цогцост шинжилгээ хийсэн бөгөөд хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй 54 цогцсыг журмын дагуу оршуулсан байна.

График 23. Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцос оршуулсан байдал (сүүлийн 10 жилийн байдлаар)





График 24. Гэмтлийн зэрэг тогтоолох шинжилгээ хийлгэсэн зонхилох хоёр шалтгаануудыг насны ангиллаар харуулав.



Хүний биед хийсэн шинжилгээ:

Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 2021 онд 17940 шинжилгээ хийгдсэнээс 12005 нь хүний биед хийгдсэн шинжилгээ байна. Үүнээс гэмтлийн зэрэг тогтоох 10972 шинжилгээ, бэлгийн маргаантай асуудалд хийсэн 1001 шинжилгээ, нас тогтоох 32 шинжилгээ байна.

Хүснэгт 8. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг шинжилгээ хийсэн шалтгаан, шинжлүүлэгчийн хүйс, насны ангиллаар харуулав.

Үзлэгийн хэлбэр, шалтгаан	Зодоон	ЗТО	Бэлгийн хүчирхийлэл	Нас тогтоох	Хутга	Буу	Бусад	ГБ зодоон	ГББХ	Нийт	
Бүгд	6309	2138	919	32	447	2	977	1099	82	12005	
Хүйс	Эр	4415	1305	318	9	371	2	594	195	7235	
	Эм	1894	833	601	23	76		383	904	4770	
	0-1	1	8	-	-	-	-	2	1	12	
Насны ангилал	1-4	11	65	29	-	-	-	37	12	7	161
	5-9	39	99	58	-	2	1	51	26	17	293
	10-14	166	106	163	12	2	-	46	32	22	549
	15-19	555	165	180	6	14	-	55	35	15	1025
	20-24	911	280	142	1	37	-	89	84	2	1546
	25-29	979	241	106	4	67	-	101	153	3	1654
	30-34	1150	266	87	-	82	1	147	268	3	2004
	35-39	868	219	55	-	58	-	106	195	3	1504
	40-44	548	186	37	2	78	-	78	131	8	1068
	45-49	416	152	21	1	40	-	81	67	-	778
	50-54	288	114	15	2	25		66	43		553
	55-59	210	80	11	2	25		61	22	1	412
	60-64	110	90	8	1	8		27	17	1	262
	65 дээш	57	67	7	1	9		30	13	-	184

Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 10972 шинжилгээ хийснээс 5.1 хувь нь хүнд, 9.6 хувь нь хүндэвтэр, 55 хувь нь хөнгөн гэмтлийн зэрэг тогтоогдсон байна. Харин нийт шинжилгээний 20.8 хувь нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй, 9.5 хувь нь гэмтэл тогтоогдоогүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Диаграмм 11. Гэмтлийн зэрэг тогтоогдсон байдал






График 25. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг шинжээч томилсон байгууллагаар нь авч үзвэл




2021 онд Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт нэг цэгийн үйлчилгээгээр 58 иргэн буюу гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 53, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 5 иргэн үзүүлсэн байна.

График 26. Нэг цэгийн үйлчилгээгээр сүүлийн 7 жилд үйлчлүүлсэн иргэдийн тоо




Хэргийн материалаар нийт 883 шинжилгээ ирснээс гэмтлийн зэрэг тогтоох 630, нас барсан шалтгааныг тогтоох 131, эмчийн үйл ажиллагаатай холбоотой 64, ялаас чөлөөлөх 24 шинжилгээ, сэтгэцийн холбогдолтой 2, эрүүл мэндийн байдал тогтоох 32 шинжилгээ байна.

Диаграмм 12. Хэргийн материалаар ирүүлсэн шинжилгээний хэлбэрүүд



Диаграмм 13. Хэргийн материалаар ирүүлсэн шинжилгээний хэлбэрүүд



Диаграмм 14. Хэргийн материалаар ирсэн шинжилгээний төрлүүд



График 27. Нийслэл дэх эрх бүхий байгууллагаас шинжилгээ томилсон байдал




График 28. Нийслэл дэх цагдаагийн байгууллагаас шинжилгээ томилсон байдал.





График 29. Хөдөө орон нутгийн эрх бүхий байгууллагаас шинжилгээ томилж ирүүлсэн байдал.




НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт шүүх эмнэлгийн чиглэлээр 1107 шинжилгээ хийсэн байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл хүний биед хийсэн шинжилгээ 88 хувийг эзэлж байна.

Хүснэгт 9. Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээг төрлөөр нь харуулав

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Цогцост хийсэн шинжилгээ	118
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	955
Хүний биед хийсэн бусад шинжилгээ / бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	23
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	11
НИЙТ	1107

График 30. Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт хийгдсэн шинжилгээгээр гэмтлийн зэрэг тогтоосон байдал





АЙМГУУДЫН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД ХИЙСЭН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд шүүх эмнэлгийн 14584 шинжилгээ хийсэн байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл хүний биед хийсэн шинжилгээ 80 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээг төрлөөр нь харуулав


Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	2112
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	11022
Хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох)	630
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	284
Эксгумац	4
Гистологийн шинжилгээ	532
НИЙТ	14584

График 31. Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийгдсэн шүүх эмнэлгийн шинжилгээ



Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд 11022 гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 11 хувиар буурсан байна. Дархан-Уул аймаг 780, Ховд аймгийн шүүхийн шинжилгээний алба 738 шинжилгээ хийсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

График 32. Цогцост хийсэн шинжилгээ



Хүснэгт 11. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ

Аймаг	Нийт гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Үзлэгээр тогтоогдсон гэмтэл				
		Хүнд	Хүндэвтэр	Хөнгөн	Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	Гэмтэл тогтоогдоогүй
Архангай	415	16	32	163	113	91
Баян-Өлгий	576	14	24	85	262	191
Баянхонгор	470	7	16	260	101	86
Булган	236	12	14	108	57	45
Говь-Алтай	399	24	18	105	145	107
Говьсүмбэр	363	7	9	102	96	149
Дархан-Уул	780	38	51	295	227	169
Дорноговь	597	30	31	217	179	140
Дорнод	585	19	44	276	143	103
Дундговь	273	5	15	120	77	56
Завхан	421	17	17	149	127	111
Орхон	678	38	57	373	108	102
Өвөрхангай	438	16	27	175	100	120
Өмнөговь	616	29	38	262	142	145
Сүхбаатар	525	28	20	166	148	163
Сэлэнгэ	626	17	49	236	172	152
Төв	574	34	67	230	154	89
Увс	486	13	28	95	195	155
Ховд	738	26	25	209	249	229
Хөвсгөл	515	30	38	269	114	64
Хэнтий	711	18	39	282	237	135
Нийт	11022	438	659	4177	3146	2602

Аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хэргийн материалаар, дахин бүрэлдэхүүнтэй шинжилгээ нийт 284 хийсэн бөгөөд үүний 109 нь нэмэлт шинжилгээ байна.

График 33. Хэргийн материалаар хийсэн шинжилгээ





График 34. Эд эсийн шинжилгээ



График 35. Эксумаци¹



¹ Эксумаци буюу цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 7 жилд хийгдсэн нийт шинжилгээний 58.2%-г шүүх эмнэлгийн шинжилгээ эзэлж байх бөгөөд шинжилгээний тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

Он	Нийт хийгдсэн шинжилгээний тоо	Шүүх эмнэлгийн шинжилгээний тоо	Шүүх эмнэлгийн шинжилгээний эзлэх хувь
2015	68237	41411	61.1%
2016	68525	40423	59%
2017	65525	38090	58.1%
2018	68424	39084	57.1%
2019	69710	40155	57.6 %
2020	64369	36974	57.4%
2021	58424	33631	57.5%

2021 онд хийгдсэн шүүх эмнэлгийн шинжилгээний нийт тоон үзүүлэлтийг урьд оныхтой харьцуулбал:

Улсын хэмжээнд

- Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 8.8% бууралттай,
- Бэлгийн маргаантай асуудалд болон нас тогтоох шинжилгээ 0.1% бууралттай,
- Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ 0.3% өсөлттэй,
- Хэргийн материалаар хийсэн шинжилгээ 0.9% бууралттай
- Шарилд хийсэн шинжилгээ 0.02% бууралттай

Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын хэмжээнд:


- Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 7.5% бууралттай,
- Бэлгийн маргаантай асуудал, нас тогтоох хийсэн шинжилгээ 0.04% бууралттай,
- Цогцост хийсэн шинжилгээ 0.6 % өсөлттэй,
- Хэргийн материалаар хийсэн шинжилгээ 2.5% бууралттай
- Шарилд хийсэн шинжилгээ 15,3% бууралттай байна.

Дээрх статистик тоон үзүүлэлтээс харахад 2021 онд хийгдсэн шүүх эмнэлгийн шинжилгээний нийт тоо үзүүлэлт нь урьд оныхоос 10%-р буурсан байна. Үүнээс цогцост хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ өссөн, харин бусад төрлийн шинжилгээнүүд буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд эдийн засгийн 191 шинжилгээ ирсэн байна. Үүнээс 130 шинжилгээний дүгнэлт гаргасан бөгөөд шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр, санхүүгийн баримт ирүүлээгүй, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гараагүй зэрэг шалтгаанаар 61 шинжилгээ буцсан байна. Шинжилгээгээр 1,760,559,956.2 мянган төгрөгийн буюу 12,211,965.4 долларын зөрчил, хохирол тогтоожээ.


Диаграмм 15 . Эдийн засгийн шинжилгээг хэргийн төрлөөр харуулав.




ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ

Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид улсын хэмжээнд 21953 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол шинжээч эмч нар 4915 хэргийн газрын үзлэгт² оролцсон байна. Криминалистикийн шинжээчдийн оролцсон хэргийн газрын үзлэгийн 23 хувь нь хүн амины, 23 хувь нь хулгайн, 18 хувь нь зам тээврийн осол, 2 хувь нь дээрмийн, 34 хувь нь бусад хэргүүд байна.

Диаграмм 16. Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгт оролцсон байдлыг хэргийн өнгөөр харуулав /улсын хэмжээнд/



Диаграмм 17. Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн биет баримт /улсын хэмжээнд




² Хүн нас барсан хэргийн газрын үзлэг бүрт шинжээч эмч нар оролцдог.

Хэргийн газрын үзлэгээр гарын мөр 15489, гутлын мөр 3058, тээврийн хэрэгслийн мөр 3401, биологийн гаралтай ул мөр 3502, эвдэгч багажны 1033, бусад ул мөр, эд мөрийн баримт 28019 ширхгийг илрүүлж, бэхжүүлсэн бөгөөд 167 хэргийн холбогдогчийг халуун мөрөөр нь олж тогтоосон байна.

КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИД ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ

Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид 2021 онд 21953 хэргийн газрын үзлэгт оролцож биет нотлох баримт илрүүлж, бэхжүүлсэн байна. Үүнээс Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын шинжээчид 49 удаа, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид 15048 удаа, Аймгуудын шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжээчид 6856 удаа хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон байна.


Диаграмм 18. Криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн газрын үзлэгийн тоо




³ ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний газрын шинжээчид нийслэл хотод болон орон нутагт гарсан онц хүнд гэмт хэргийн газрын үзлэгт багийн зохион байгуулалттайгаар оролцдог.

НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИД ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ

График 36. Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн газрын үзлэгийн тоо



Диаграмм 19. Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн өнгө



ОРОН НУТГИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИД ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ

2020 онд аймгуудын шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжээчид нийт 7915 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол 2021 онд 6856 болж, 13.3 хувиар буурсан байна.

График 37. Сүүлийн 2 жилд аймгуудын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн газрын үзлэгийн тоо





График 38. Аймгуудын шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн газрын үзлэгийн тоо



ШИНЖЭЭЧ ЭМЧ НАР ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ

Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд шинжээч эмч нар 4915 хүн амины хэргийн газрын үзлэгт оролцсоноос 2658 буюу 54 хувьд нь Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын шинжээч эмч нар, 2139 буюу 43.5 хувьд нь аймгуудын шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмч нар оролцсон байна.

Диаграмм 20. Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, Нийслэлийн шүүхийн шинжилгээний алба болон аймгуудын шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмч нар хэргийн газрын үзлэгт оролцсон тоо




График 39. Аймагуудын шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмч нар хэргийн газрын үзлэгт оролцсон тоо

